



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2013 оны 08 сарын 16 өдөр

Дугаар 143

Мандалговь


Хөрөнгө худалдах тухай.

“Төрийн болон орон нутгийн өмчийн” тухай хуулийн 77 дугаар зүйлийн 3 Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журмын 3 дугаар зүйлийн 3.1 “в”, 3.2.6 “а”, 4 дүгээр зүйлийн 4.1 дэхь заалтуудыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Дэрэн сумын Соёлын төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 4599034 төгрөгийн анхны өртөгтэй, 3104348 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй Халуун усны барилгыг сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн худалдах үнийн доод хязгаарыг 1500000,0 /нэг сая таван зуун мянган/ төгрөгөөр тогтоож дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Дуудлага худалдаагаар худалдагдсан барилгыг зохих журмын дагуу бүртгэлээс хасахыг Дэрэн сумын Соёлын төвийн эрхлэгч /Ч.Одончимэг/-д даалгасугай.

3. Орон нутагт дуудлага худалдааг хууль, дүрэм журмын дагуу явуулж, орсон орлогыг орон нутгийн 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн алба /П.Очирбат/-нд үүрэг болгосугай.

ДАРГА  С.БУДЖАВ

